

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.040.01

Агаарын чанар. Ерөнхий ухагдахуун. Хэмжих нэгж Air quality – General aspects-Units of measurements	MNS ISO 4226:2000
---	--------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2000 оны 03-р сарын 30-ний өдрийн 84 дугаар тогтоолоор батлав.

2000 оны 04 -р сарын 01 -ний өдрөөс эхлэн 2005 оны 04 -р сарын 01-ний өдөр хүртэл хүчин төгөлдөр болно.

Энэ стандартыг бүхэлд нь заавал мөрдөнө.

Оршил

Агаарын шинж чанарын талаарх Олон улсын стандартын цуврал нь хий, уур ба жижиг хэсгүүдийг хэмжих аргуудын стандартчлалд хамаарна.

Улс дотоодын болон улс хоорондын үр дүнг харьцуулахын тулд үр дүн болон бусад холбогдох мэдээллийг тайлагнахдаа зөвшөөрөгдсөн хэмжих нэгжүүдийг хэрэглэх нь зайлшгүй. Түүнчлэн хэмжих нэгжүүдийг аль болох цөөн болгох нь зохимжтой.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь агаарын чанарын хэмжилтүүдийн үр дүнг мэдээлэхдээ ашиглах нэгжүүд болон тэмдэглээг тогтооно. Олон улсын нэгжийн системийг ерөнхий зөвлөмж болгон хэрэглэх ба ISO 1000:1992 (SI units and recommendations for the use of their multiples and of certain other units) тоот стандартыг иш татна.

2. Нэгжүүд

1-р хүснэгтийг үзнэ үү.

1-р хүснэгт

№	Тоо хэмжээ	Нэгж	Тэмдэглэгээ
2.1.	Бодисын нэгж		
2.1.1.	Хий ба уур		
2.1.1.1	Гол бүрдүүлэгчийн эзэлхүүний буюу жингийн хувь (жишээ нь, агаар дахь азот, хүчилтөрөгч, нүүрстөрөгчийн давхар оксид)	хувь (эзэлхүүнээр) хувь (жингээр)	% %
2.1.1.2	Хийн байдалтай бохирдуулагчийн эзэлхүүний хувь	саяны нэг хувь (10^{-6})	ppm
2.1.1.3	Хийн байдалтай бохирдуулагчийн жингийн хувь ¹	куб метрт миллиграмм куб метрт микрограмм куб метрт нанограмм куб метрт пикограмм	мг/м ³ мкм/м ³ нг/м ³ пг/м ³
2.1.2.	Жижиг хэсэг		
2.1.2.1	Аморф бодисын жингийн хувь	куб метрт миллиграмм	мг/м ³

		куб метрт микрограмм куб метрт нанограмм куб метрт пикограмм	мкм/м ³ нг/м ³ пг/м ³
2.1.2.2	Жижиг хэсгийн хэмжээ	микрометр	мкм
2.1.2.3	Агаарын тоос ² (тунадас хэмжигч)	квадрат метр-өдөрт грамм квадрат метр-өдөрт миллиграмм	г/(м ² -өдөр) мг/(м ² -өдөр)
2.1.2.4	Биологийн, микробиологийн ба бусад аморф бодис (тухайлбал, цэцгийн тоос, спор, бичил биетэн)	куб метр куб дециметр	м ³ дм ³
2.2.	Хийн төлөв байдлыг тодорхойлох нэгжүүд		
2.2.1	Термодинамик температур	кельвин	К
2.2.2.	Цельсийн температур	цельсийн градус	°С
2.2.3.	Даралт	паскал килопаскал	Па кПа
2.2.4.	Харьцангуй чийглэг	хувь	%
2.3.	Цаг агааарыг илэрхийлэх		
2.3.1.	Салхины хурд	секундад метр	м/с
2.3.2.	Салхины чиглэл ³	хэм	°
2.3.3.	Тунадасны эрчим	өдөрт миллиметр цагт миллиметр	мм/өдөр мм/ц
2.3.4.	Цацраг туяа	квадрат метрт ватт	Вт/м ²
2.3.5.	Агаарын даралт	килопаскал	кПа
2.4.	Хугацаа		
2.4.1.	Хугацаа	секунд минут цаг өдөр	с мин ц өдөр
2.5.	Бусад		
2.5.1.	Газарзүйн байрлал [хойд (Х) буюу өмнөд (Ө) өргөрөг] [зүүн (З) буюу баруун (Б) уртраг] ⁴	хэм минут секунд	° ' "
2.5.2.	Далайн түвшнээс дээших өндөр	метр	м
<p>1) Хэрвээ концентрацийг нэгж эзэлхүүн дэхь жингээр илэрхийлж байгаа бол температур, даралтын хэмжилт (түүнчлэн чийглэг) шаадлагатай. Хийн байдалтай бохирдуулагчдийг заримдаа мг/л (литрт миллиграмм)-аар илэрхийлдэг.</p> <p>2) Тунадас авагчийг хэрэглэж байгаа үед агаарын (агаарын тоосжилттай үед) эзэлхүүнийг тооцохгүй. Агаарын тоосжилтыг цуглуулсан хугацааг мэдээлнэ.</p> <p>3) Цагийн зүүний дагуу хойд чиглэлийн 0° -ээс эхлэн 360° хүртэл бүтэн тойрог гэж хэмжсэн өнцөг, хэмээр өмнө нь салхины чиглэлийг мэдээлж байсан.</p> <p>4) Хойд өргөрөгийн хэмийн тооны өмнө +, өмнөд өргөрөгийн хэмийн тооны өмнө - тавьж болно. Гринвичийн уртрагийг харгалзан үзэж уртрагийг мөн +,- тэмдгээр тэмдэглэнэ. +баруун уртраг, - зүүн уртраг</p>			

ТӨГСӨВ.